

О.Чимэг

Шашин судлалын тэнхимийн  
багш, доктор, дэд профессор

**Ф.Ницшегийн философи дахь эзэрхэх  
хүсэл зоригийн тухай сургаал**

**Түлхүүр үг:** Амьд организм, үнэт зүйлс, ёс суртахуун, нийгэм

**ЭШӨ-ийн товч утга:** Амьдралын философийн ууган төлөөлөгчдийн Ф.Ницшегийн философийн гол ойлголт болох эзэрхэх хүсэл зоригийн тухай сургаал, түүнтэй холбоотой үнэт зүйлс, ёс суртахууны тухай үзэл баримтлал нь “бүх үнэт зүйлсийг эргэн харах” тулгуур үндэс болжээ.

“Амьдралын философийн” ууган төлөөлөгчдийн нэг, XX зууны философийн урсгал чиглэл, ерөөс нийгэм- улс төрийн сэтгэлгээнд үлэмж нөлөө үзүүлсэн Ф.Ницшегийн үзэл санааг “нийгмийг хувирган өөрчлөх” XX зууны философийн үндсэн хоёр урсгалын нэг гэж үзэж болох юм. Түүний философийн судалгаа нь иррационалист чиглэлийг ойлгоход төдийгүй шашин, ёс суртахуун, шинжлэх ухаан, нийгэм-улс төрийн харилцаа зэрэг нийгмийн олон үзэгдлийг тогтолцооны нь хувьд өргөн хүрээнд авч үзэх бололцоо олгох ач холбогдолтой юм.

Ф.Ницшегийн философийг Европын олон оронд судалдаг бөгөөд түүний философийн талаар бусад улс орнуудад янз бүрийн ойлголт төсөөлөл байдаг байна. (11)

Түүний нэлээд нөлөөлсөн экзистенциалист философийн нэг гол төлөөлөгч М.Хайдеггер түүнийг европын философийн уламжлалыг туйлд нь хүргэсэн гэж үзэж байв. Ницшегийн философийг тэрээр субъектив эриний логик төгсгөл гэж нэрлэсэн. (6)

Нийгэм-улс төрийн баримтлалын хувьд эзэрхэх хүсэл зоригийг амьдралын гол тодорхойлогч шинж болгосон Ницшегийн үзэл баримтлалыг М.Хайдеггер дэлхийг ноёлохын төлөө тэмцлээр тодорхойлогдох шинэ эриний тунхаглал хэмээн үзсэн. (6)

Ф.Ницше марксист философийн зарим сурах бичгүүдэд социализмын эсрэг, хүчтэй хүнийг магтан дуулагч гэх байдлаар авч үзсэн нь бий. (10)

Дуулгавартай дэглэмийн эсрэг гэдэг утгаар түүнийг социализмын дайсан байсан гэж үзэж болох юм.

Эдгээр бүх ойлголтууд түүний философийн тулгуур болдог эзэрхэх хүсэл зориг ба үлэмж хүний тухай сургаалтай холбоотой.

Эзэрхэх хүсэл зоригийн тухай ойлголтыг эзлэн түрэмгийлэх явцуу утгаар хязгаарлаж болмооргүй байна. Эзэрхэх хүсэл зоригийн тухай ойлголт нь амьдралын бүтээлч мөн чанар, юманд эзэн болох гэсэн илүү өргөн утгатай юм.(14)

**1.Нэр томъёоны орчуулгын тухай.**

Ф.Ницшегийн философийн нэг зангилаа ойлголт бол эзэрхэх хүсэл зоригийн тухай ойлголт. Энэ нэр томъёог “засаглал” гэсэн үг оруулан орчуулах нь ажиглагддаг. Энэ нэр томъёог хэрэглэх нь “засгийн эрхийн төлөө тэмцэх” маягийн явцуу ойлголтыг төрүүлж болохоор тохиромжгүй нэр томъёо мэт санагддаг. Герман хэлээр энэ нэр томъёо ямар утга санааг багтаадаг талаар олж мэдэх бололцоо олдсонгүй. Харин орос орчуулгуудад хэрэглэсэн нэр томъёо төдийгүй орос хэлээр гарсан гол зохиолуудын нь үзэл санаагаар аваад үзэхэд энэ нэр томъёо “засаглал” гэхээсээ илүү “эрх мэдэлтэй болох” гэсэн ойлголттой илүү дөхөж очих мэт. Гэвч оросоор “воля к власти” хэмээн орчуулагдаж ирсэн энэхүү нэр томъёо юманд эзэн болох, эзэмших гэсэн утга санааг илэрхийлдэг. Нөгөө талаар ерөөсөө “эрх мэдэлтэй байна” гэдэг ойлголт ч эзэн болох утга санааг тодорхой хэмжээгээр багтааж байдаг учраас Ф.Ницшегийн философийн энэхүү гол нэр томъёог “эзэрхэх хүсэл зориг” хэмээн орчуулж байгаа юм. (14)

Мөн түүнчлэн түүний философид “отношения власти” гэсэн нэр томъёо чухал байр суурь эзэлдэг. Энэ нэр томъёог “засаглалын харилцаа” гэхэд тохиромжгүй гэж хувьдаа үзсэн бөгөөд “эзэрхлийн харилцаа” хэмээн томъёолсон. Монголоор эвтэйхэн сонсогдохгүй байгаа “эзэрхлийн харилцаа” гэсэн томъёоллын оронд “эзэн харьяатын харилцаа” гэсэн нэр томъёог хэрэглэвэл утга санааны хувьд нэг их зөрүү гарахгүй мэт болов уу. Ямар боловч “эзэн” гэсэн язгууртай үгийг хэрэглэх нь олон талын утга санааг багтаасан тохиромжтой ойлголт мэт санагдаж байгаа юм. Гэвч “найрлага”, төрж болох ташаа буруу ойлголтыг бодолцон энэ удаа “эрх мэдлийн харилцаа” гэсэн нэр томъёог хэрэглэлээ.

**2.“Эзэрхэх хүсэл зоригийн” тухай үзэл санааны зарим эх сурвалж ба хожмын философид үзүүлсэн нөлөө.**

Ц.Ницшегийн философид онцгой нөлөө үзүүлсэн философич бол А.Шопенгауэр (7) юм.

Эзэрхэх хүсэл зоригийн тухай түүний гол үзэл санааны уг сурвалж Шопенгауэрын философи дахь “хүсэл зоригийн” тухай ойлголттой холбоотой.(7) Гэвч “Дэлхий ертөнц хүсэл зориг ба төсөөлөл болохынхоо хувьд юу болох нь”

зохиолоороо залуу Ницшег бишрүүлсэн (9) Шопенгауэрын философид хүсэл зоригоос чөлөөлөгдөж тайвшрал олохыг ертөнцийг үзэх үзлийн хэмжээнд тунхагласан (13) бол Ницшегийн философид хүсэл зориг нь "эзэрхэх хүсэл зориг" болж, ертөнцийг үзэх огт өөр үзлийн үндэс суурь болжээ.

Ф.Ницшегийн философи дахь эзэрхэх хүсэл зоригийн тухай үзэл санааг улс төрийн харгис хэрцгий практикт ашиглаж байсан гэдэг. Энэ үйл ажиллагааг зарим судлаачид түүний үзэл санааг гуйвуулсантай холбосон байх төдийгүй хэвлэгдээгүй өвийг нь дур зоргоор эмхтгэн найруулсан нь хожим хойно нотлогдсон тухай өгүүлжээ.(11)

Ф.Ницшегийн зохиолуудын үзэл санаанаас үзэхэд түүний философи улс төрийн харгис хэрцгий практикт ашиглагдаж байсныг явцуу тайлбартай холбоотой гуйвуулга мөн хэмээн үзэх бүрэн үндэстэй юм. Түүний үзэл санаа амьдралын дотоод мөн чанарыг өргөн хүрээнд илэрхийлэх бөгөөд улс төрийн амьдралтай холбон үзвэл бас л дотоод мөн чанарыг нь тусган харуулсан гэж үзэж болмоор Харгис хэрцгий практикийн хувьд тэрээр адгууслаг чанар хүнд байдгийг тусган харуулсан байх боловч жигшин зэвүүцсэн байх нь олонтаа үзэгдэнэ. Тийм боловч түүний үзэл санаа түрэмгий бодлогод ашиглахад тохиромжтой байсныг үгүйсгэж болохгүй мэт.

Эзэрхэх хүсэл зориг буюу амьдралыг бүхэлд нь дотоодоосоо гадагш хандсан хэмжээ хязгааргүй тэмүүлэл болгосон Ницшегийн үзэл санаанаас хожмын экзистенциалист философи дахь "Нээлттэй чанарын" тухай ойлголт эх үүсвэртэй болов уу. "нээлттэй чанар" гэсэн нэр томъёог философидоо оруулж хэрэглэсэн М.Хайдеггерын эрэл хайгуул, үнэний тухай эргэцүүлэлд нь Ницшегийн философид нэвт шингэсэн энэ үзэл санаа чухал нөлөө үзүүлсэн нь илэрхий мэт байдаг. (12,15)

"Нээлттэй чанар" гэдэг нэр томъёогоор М.Хайдеггерын хэрэглэсэн утга санаа Ницшегийн дионисч хүчний тухай ойлголттой холбоотой. Өөрийгөө Дионис тэнгэрийн сүүлчийн шавь хэмээн нэг бус удаа нэрлэж байсан түүний үзэл санаанд дионисч зөн совин бол амьдралын хүч тэмүүлэл, амьд бүхний гол чанар бөгөөд үзэл санааны нь хөгжлийн явцад эзэрхэх хүсэл зориг болж алдаршсан. Дионисч зөн совин нь амьд бүхэн дэх өсөлтөнд тэмүүлсэн, дотоодоос гадагш чиглэсэн "нээгдэх" чанарыг илэрхийлсэн ойлголт юм. Бүгдийг тэгшитгэж, хийсвэр ойлголтонд захируулсан ухаалаг, ухамсарт эринд давамгайлсан зөн совиндоо амьдралаа зориулж, уран сайхны бүтээл туурвил болгож хувиргасан учраас тэрээр өөрийгөө Дионис тэнгэрийн сүүлчийн шавь гэж нэрлэсэн болов уу. "Заратуэстра тийнхүү ярьж байв" хэмээх түүний гол зохиол

гүнзгийрэн задарч байдаг нээлттэй утга агуулгаараа бэлгэдэлтэй зүйрлэж болохоор байдаг. (2)

**3. Амьд организм бүр эзэрхэх хүсэл зориг болох нь.**

Ф.Ницшегийн философи дахь эзэрхэх хүсэл зоригийн тухай үзэл санаа "Сайн, муугийн чинад хязгаараа" гол зохиолынх нь нэгэнд юуны өмнө тусгалаа олсноос гадна (3) бусад зохиол, түүний дотор "Заратустра тийнхүү ярьж байв" гол зохиолд нь нэвт шингэсэн байна. (2,4,5)

Эдгээр зохиолын үзэл санаанаас үзэхэд эзэрхэх хүсэл зоригийн тухай ойлголтыг юуны өмнө танин мэдэхүйн өргөн хүрээнд авч үзэх нь зүйтэй санагдана.

Нөгөө талаар энэхүү ойлголтыг орчинтойгоо нэг ёсоор "бодисын солилцоо" явуулж буй амьд организмын өсөлт бууралтын ээлж дараагаар төсөөлөн ойлгож болмоор байгаа юм. Амьд организмын энэхүү үйл ажиллагаанд хувь хүн төдийгүй нийгэм нэгэн адил хамрагдах нь түүний зохиолуудад олон талаар тусгагджээ.

Түүний анхны томоохон бүтээл "Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу эллин ёс ба гутрангуй үзэл" зохиолд эзэрхэх хүсэл зоригийн тухай үзэл санааных нь эх үүсвэр тавигджээ.

Хэрэв энэ зохиолд эмпирик ертөнцийг ямар нэгэн анхдагч хүсэл зоригийн зовлон зөрчил чөлөөлөгдөх илэрхийлэл, тайлал хэмээн үзэж байсан бол үзэл санааныхаа хөгжлийн явцад тэрээр амьдралыг бүхэлд нь төдийгүй дэлхий ертөнцийг эзэрхэх хүсэл зориг хэмээн үзэх болсон. Энэ үзэл санаа нь хоорондоо зөрчил үгүй, харин анхны үзэл санааных нь хөгжил гэж үзэж болохоор байна. Энэ бүтээлийн үзэл санаагаар эмпирик ертөнцийг анхдагч хүсэл зоригийн тайлал, урлагийг хүний сэтгэлийн тайлал, объектлол буюу статик агшныг агуулсан байдлаар төсөөлж болох юм.

Амьдралын хүч, дионисч авьяасны элбэг дэлбэг, бүрэн дүүрэн шинж дионисч танин мэдэхүйн хэтэрхийллээр илрэн гарч, энэ хүч чадлын тайлал нь аполлонч ертөнцийн үзэгдэл буюу санааны ертөнц, түүний бүтээгдэхүүн болох бүтээл туурвил, бүхий л үйл ажиллагаагаар илэрч байдаг.

Ницшегийн үзэл санаан дахь эзэрхэх хүсэл зориг нь амьдрах хүч тэмүүлэл, байгалиас заяасан түлхэц энерги мөн бөгөөд амьдралын үндсэн шинж, мөн чанар нь юм. Энэ утгаар эзэрхэх хүсэл зоригийг "Эмгэнэлт жүжгийн гарал үүсэл буюу эллин ёс ба гутрангуй үзэл" анхны том зохиолынх нь дионисч хүчинтэй адилтгаж болно.



“Эзэрхэх хүсэл зоригийн” тухай ойлголтыг амьдралын бүтээлч мөн чанарыг илэрхийлсэн ойлголт гэж үзэж болох юм. Амьдралын тухай Ницшегийн энэхүү үзэл санаа угтаа амьд организм үүсч, хөгжиж, мөхөх тухай үзэл санаа юм.

Ницшегийн үзэл санаагаар амьдралын гол шинж бол өөрийгөө нэг хэвэнд хадгалан хамгаалах явдал бус, харин “дээш, улам дээш” өгсөн өндийх явдал. Амьдралын энэхүү гол мөн чанарыг тэрээр эзэрхэх хүсэл зоригийн тухай ойлголтоороо илэрхийлжээ. Харин өөрийгөө хамгаалахуй нь эзэрхэх хүсэл зоригийн тойруу бөгөөд олон тосны үр дагварын нэг төдий ажээ.

Түүний үгээр “ямар нэгэн юм хүчээ илэрхийлж байхыг хүсдэг-амьдрал өөрөө эзэрхэх хүсэл зориг мөн өөрийгөө хамгаалахуй нь үүний тойруу бөгөөд олон тооны үр дагаврын нэг төдий юм” (3:250)

Энэ үзэл санааны дагуу амьд организм бүр хүсэл тэмүүлэл, хазаарлал тайвшралын ээлж дараанд оршиж байдаг бөгөөд хүсэл тэмүүллийн тал нь ноёлогч шинж, тайвшрал хазаарлалын тал нь дагалдагч буюу хоёрдогч шинж юм. Амьд бүхний мөн чанар бол байнгын үйл ажиллагаа бөгөөд үүнийг бодисын солилцоотой зүйрлэж болмоор санагдана. Орчинтойгоо “бодисын солилцоо” явуулна гэдэг бол орчиндоо тэмүүлж, “эзэмшин” өөрийн болгож, нөгөө талаар түүндээ идэвхтэй нөлөөлнө гэсэн үг.

Аливаа амьд организм тодорхой эрчтэй төрдөг бөгөөд өсч, хөгжиж, бууралтанд орж, эцэстээ мөхөж үрэгддэг. Гэвч энэ хөгжил хоосон үл өнгөрнө. Хуучин организм дотоодоосоо өөр организм буюу шинэ хүсэл зоригийг төрүүлж шинэ организм нь хуучин организмын үргэлжлэл байдаг билээ. Солигдон буй эдгээр организмыг бүхэлд нь нэг организмын өсөлт хөгжилт гэж ч үзэж болох юм. Нөгөө талаар аливаа амьд организм бол гол функцид захирагдсан функциудын нэгдмэл цогц. Түүнийг нэгтгэж буй гол функцийг Ф.Ницше давамгайлсан зөн совин гэж нэрлэсэн. Тэрхүү давамгайлсан зөн совин үйл ажиллагаа явуулах зорилго чигийг тодорхойлох бөгөөд бусад функциуд түүнд захирагдсан шинжтэй байдаг.

Ницшегийн үзэл санааны хүрээнд энэхүү давамгайлсан зөн совин амьд организмын хөгжлийн явцад дараах байдлаар өөрчлөгдөнө хэмээн төсөөлж болох юм.

Анх төрж буй организм амьдрах чадвартай бол орчны эсэргүүцлийг давж өсөлтийн явцад улам бэхжин чангардаг. Харин хүч тэнхээ буураад ирсэн цагт, өөрөөр хэлбэл тухайн организмд заяасан эрч барагдахад энэхүү организмын орчинтойгоо “бодисын солилцоо” явуулах эрч буурч ядралд ордог.

Тэр цагт тухайн организм амьд явах нөхцлөө хангахын тулд биеэ нөөж эхэлдэг бөгөөд эрч хүчээ арвилан хэмнэж, хүсэл зориггоо барих явдал давамгайлсан зөн совин нь болдог. Үүнийг өөрийгөө “боох” хүсэл зориг гэж нэрлэж болно. Энэ үед “санааны” хүсэл зориг, бясалгал, “шинжлэхүй ухаан” шууд үйл ажиллагаанаас давамгайлна. Гадаад ертөнцөөс “уйдах” болсон энэхүү давамгайлсан хүсэл зориг амьд организмын оршихуйг хадгалан хамгаалахын тулд бусад “хүчтэй” зөн совингуудыг дарах болдог.

Ертөнцөөс харин уйдах, “өөр” буюу туйлын амар амгалангийн ертөнцөд чиглэсэн энэхүү тэмүүллийн ялалт организмын үхэлтэй давхацна.

Харин энэхүү организм дотоодоосоо өөр организм төрүүлсэн, тэр нь амьдрах чадвартай бол бүхий л цогцос амьдрах ирээдүйтэй.

Ийнхүү үйл ажиллагаа явуулах зорилго, чигт хүрэхийн тулд организмын функциуд гол зөн совин буюу функцдээ захирагддаг.

Захирагдана гэдэг бол тухайн зорилгыг биелүүлэхэд хэрэгтэй зүйлд биеэ дайчилж, үүнд үл хамаарах буюу саад болсон зүйлийг огоорох, орхин хаях, өөрөөр хэлбэл зохих шинжүүд шалгаран тэтгэгдэж, бусад нь дарагдана гэсэн үг.

Дэмжиж тэтгэгдэж, орхигдон дарагдаж буй шинжүүдийн тухай ойлголтыг ёс суртахуун буюу “сайн”, “муугийн” тухай ойлголт илэрхийлдэг.

Зорилго хийгээд түүнд хүрэхэд ямар шинжүүдийг дэмжин тэтгэхийг давамгайлсан зөн совин тодорхойлдог.

Өсч хөгжиж буй организм гадаад орчиндоо татагдан тэмүүлж, идэвхтэй үйл ажиллагаа явуулж, биеэ хадгалан барихаас илүү есөлтийг эрэлхийлж, есөлтөнд шаардлагатай идэвхтэй “бодисын солилцоо” явуулдаг бол буурч буй организмд орчноос биеэ хураах, эрчмээ нөөх явдал давамгайлдаг.

Ингэхлээр зорилго хийгээд түүнд хүрэхэд шаардлагатай, дэмжин тэтгэгдэж, “сайны” үнэлгээ авдаг шинжүүд буюу ноёлогч ёс суртахуун, давамгайлсан зөн совингийн илэрхийлэл бөгөөд тухайн организмын хөгжлийн үе шатыг харуулна.

Амьд организм бүр эзэрхэх хүсэл зориг болох тухай Ницшегийн үзэл санааг ийнхүү илэрхийлж болмоор санагдаж байгаа юм. ХХ зууны эхэнд нэлээд анхаарал татсан О.Шпенглерийн “Европын бууралт” зохиолын үзэл санаанд Ф.Ницшегийн философи нөлөө үзүүлсэн болов уу гэж бодогдож байгаа юм. Гэвч энэ талаар баримт мэдээ цуглуулж судлаагүй гэдгээ тэмдэглэн хэлье.

#### **4. Үнэт зүйлсийн тухай сургаал**

Ницшегийн үзэл санаанд амьдрал бол мөнхийн тэмүүлэл. Гэхдээ энэ тэмүүлэл бол хоосон тэмүүлэл бус, харин ямар нэгэн зүйлд тэмүүлж, “эзэмшин” өөрийн болгож түүнд идэвхтэй нөлөөлөхөд чиглэсэн эзэрхэх хүсэл зориг.

Амьдралын зорилго бол нэг хэвэндээ байх, биеэ хадгалан хамгаалах явдал бус, харин байнгын өсөлт бөгөөд үүнд чиглэсэн байнгын үйл ажиллагаагүйгээр амьдрал мөхнө. Энэхүү байнгын үйл ажиллагаа орчны тодорхой эд юмсад чиглэх бөгөөд физиологийн шаардлагатай холбоотой байдаг. Хүсэж зорьсон зүйл гэдгээс үнэт зүйлсийн тухай Ницшегийн тухай ойлголтыг гаргаж болох юм.

Түүний үзэл санааны дагуу хүсэл зоригийн тогтолцоо бүр үнэлж тэмүүлэх зүйлс, зорилгын хэрэгцээтэй байдаг. Үнэт зүйлсийн энэхүү хэрэгцээг буддын философид өмчнийг бий болгох, минийрхэн барих гэх зэрэг ойлголтоор илэрхийлдэг.

Үнэт зүйлсийн тухай сургаал түүний анхны томоохон бүтээл болох “Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу эллин ёс ба гутрангуй үзэл” зохиол дахь хүсэл зоригийн илэрхийлэл тайллын тухай ойлголтоос хөгжсөн гэж үзэж болмоор санагдана.

Энэ бүтээлийн үзэл санаагаар эмпирик ертөнцийг анхдагч хүсэл зоригийн тайлал, объектчлал буюу статик агшныг агуулсан байдлаар төсөөлж болох бол “Заратустра тийнхүү ярьж байв” зохиолд үнэлэмжийг эзэрхэх хүсэл зоригийн илэрхийлэл, өөрийнх нь физиологийн шаардлага буюу өсөлтөнд тэмүүлдэг амьдралын мөн чанараас урган гардаг бодит хэрэгцээ болгон илэрхийлсэн байна.

Хүний үнэлэн тэмүүлж буй зүйлийг үнэт зүйл гэх бөгөөд, “үнэлэх замаар үнэт зүйлс бүтдэг;” үнэлгээний замаар анх эхлээд үнэт зүйл бий болдог, үнэлгээгүйгээр ахуйн боргоцой хоосон байх байсан” хэмээн “Заратустра тийнхүү ярьж байв зохиолдоо бичжээ. (2,42)

Ницшегийн философи дахь үнэт зүйлсийн тухай сургаалыг ерөөс амьдралын утга учрын асуудалтай утга нэгэн зүйл гэж хэлж бас болох юм. Тэрээр хэлэхдээ: “Хүн өөрийгөө хадгалан хамгаалахын тулд эхлээд юмсад үнэт зүйл нийлүүлдэг байв,- тэрээр эхлээд юмсад утга учир, хүмүүнлэг утга учир бүтээв. Тиймээс тэрээр өөрийгөө хүмүүн буюу үнэлэгч хэмээн нэрийднэ”. (2,42)

Түүний үзэл санааны дагуу хүний үнэлэмж, юмсыг үнэ цэнэтэй хэмээн үзэж, тэдгээрт тэмүүлэх явдал амьдралынх нь утга учир болж байдаг ба энэхүү үнэлэмж нь тухайн амьд организмын мөн чанараас нь урган гарч байдаг байна. “Заратустра тийнхүү ярьж байв” зохиолдоо Ф.Ницше “тухайн хүний юмсын талаархи үнэлгээ тэрээр юуг амьдралын нөхцлөө, юуг үнэнхүү хэрэгцээгээ гэж үзэж байгааг илэрхийлнэ” (2,292) гэсэн. Харин давамгайлсан зөн совин нь зорилго болж буй үнэт зүйлсийг тодорхойлж, бүрэлдэхүүн нь болж байдаг.

Энэ утгаар үнэлэмжийг хандлага, үнэт зүйлийг гол зорилго ч гэж хэлж болно.

Эрхэм зорилго буюу үнэт зүйлс гэдэг нь тухайн амьдрал, тухайн амьд организмын өөдлөх нөхцөл, амьд амьтны өсөлтөнд нь шаардлагатай зүйл. Гэхдээ амьдрал бол ялгарал. Тийм учраас үнэлэх зүйлс нь ч ялгаатай байх учиртай. “Амьдрал бол үнэлэх, илүүд үзэх, шударга бус байх, хязгаарлагдмал байх, бусад зүйлээс ялгаатай байх хүслээс тогтох бус уу?” (3:246)

Тийм учраас орчиндоо нөлөө үзүүлж өөрийгөө хэрэгжүүлэх арга зам, арга хэлбэр өөрөөр хэлбэл үнэлэх зүйлс нь өөр өөр байдаг.

Амьд организмын дотоод үнэлэмжийг илэрхийлэх гол ойлголтын хувьд Ф.Ницшегийн философид ёс суртахууны асуудал тавигддаг.

**5. Амьд организм эрх мэдлийн харилцаанд үүсдэг тухай ёс суртахууны сургаал.**

Үнэт зүйлс, сайн, муугийн тулгуур баримжааг илэрхийлдэг ёс суртахууны тухай Ницшегийн ойлголтыг давамгайлсан хүсэл зориг, ноёлогч үнэлгээний тухай ойлголттой адилтган үзэж болох юм. Давамгайлсан хүсэл зориг нь ноёрхож, араасаа дагуулдаг зөн совин бөгөөд гаргаж буй үнэлгээ үнэлж буй амьдралын онцлогоос урган гардаг ажээ.

Аливаа хүсэл зориг буюу “би” нь захирах, захирагдах дэд хүсэл зоригуудын нийгмийн байгууламж гэж Ф.Ницше амьдралыг бүхэлд нь ёс суртахууны үүднээс авсан үзсэн. Түүний үзэл санааны дагуу хүсэл зориг нь тушаан захирах нэгдмэл хүсэл зориг бөгөөд дотоод итгэлээрээ өөрийн гэж үздэг дэд хүсэл зоригуудыг өөртөө багтааж байдаг. Тэрээр амьдралыг бүхэлд нь эзэрхэх хүсэл зориг гэж үзэж байсан тул тушаан захирагч давамгайлсан хүсэл зориг хийгээд түүнд захирагдан дуулгаварлах дэд хүсэл-зоригуудын нэгдэл болох утгаараа хувь хүн төдийгүй нийгэм энэхүү ойлголтөнд хамаарч байгаа юм. Үүнтэй холбогдуулан Ницше хүсэл зоригийн тухай ойлголтыг авч үзэхдээ ноёрхогч анги нийгмийн ололт амжилттай өөрийгөө адилтгаж байдгийг жишээ болгосныг ч тэмдэглэж болно. Эзэрхэх хүсэл зоригийн тухай ойлголт Ницшегийн гол баримтлал болохыг харгалзан энэ талаархи түүний үгийг бүрэн эхээр нь толилуулъя: “Ийнхүү, хүсэгч нь захиран тушаагчийн тушаал ханамжийн сэтгэл мэдрэмж дээр бас гүйцэтгэгч, амжилттай үйлдэгч багаж зэвсэг, туслах чанартай “дэд хүсэл зориг” буюу дэд-сэтгэл мэдрэмжүүдийг нэмж холбодог-учир нь бидний бие олон санаа сэтгэлийн нийгмийн байгууламж төдий мөн шүү дээ. : (Үйлдэл бол бифр) ноёрхогч анги нийгмийн ололт амжилттай өөрийгөө адилтгаж байдаг сайн сайхан аж байдалтай, аз жаргалтай нийгэмлэг бүрт



тохиолддог зүйл энд илэрч байна. Аливаа хүсэмжийн үед дээр хэлсэнчлэн, олон "санаа сэтгэлийн" нийгмийн байгууламжийн хөрс суурин дээр захиран тушаах хийгээд дуулгаварлах тухайд хэрэг нь байдаг учир философич хүн хүсэмжийг дангаар нь ч ёс суртахууны үүднээс авч үзэх эрхтэй гэж үзэх ёстой, тэгэхдээ ёс суртахуун гэдэгт чухамдаа "амьдрал" гэдэг үзэгдэл эрх мэдлийн харилцаанд үүсдэг тухай сургаалыг ойлгож байна". (3:255)

Ийнхүү Ницшегийн философид ёс суртахуун гэдэг бол бусад бүх зөн совин үг дуугүй захирагдах ёстой ноёлогч зөн совин, давамгайлсан аффект бөгөөд амьдрал гэдэг үзэгдэл эрх мэдлийн харилцаанд үүсдэг тухай сургаал юм.

Амьдралыг бүхэлд нь эрх мэдлийн харилцаанд авч үзсэн Ницшегийн үндсэн баримтлалд түүний анхны зохиол дахь дионисч хүч буюу түлхэц эрчим хүч амьдралын гол буюу ноёлогч шинж, харин аполлонч буюу тайвшрал хазаарлалын тал хоёрдогч буюу дагалдагч шинж болж хувирчээ.

Амьдралын энэ хоёр талын аль нь давамгайлж байгаагаар, өөрөөр хэлбэл ноёрхогч ёс суртахуунаар амьдрал ямар байгааг тодорхойлж болно гэж тэрээр үзжээ

#### **6. Амьд организмын өсөлт бууралт**

Эзэрхэх хүсэл зоригийн тухай Ф.Ницшегийн ойлголтыг нийгмийн философийнх нь үндсэн ойлголт гэж үзэж болно. Түүний үзэл санааны хүрээнд амьд организм болох нийгэм нь мөн л эзэрхэх хүсэл зоригийн хөгжилт юм.

Өсөлт бууралтын ээлж дараанд байдаг амьдрал, амьд организмын тухай энэхүү үзэл санаа нь ёс суртахууны үзэл баримтлалынх нь төдийгүй "бүх үнэт зүйлсийг эргэн харахыг" зорьсон бүхий л философийнх нь үндэс болсон байна.

Өсч буй амьдрал өөрт нь, өөрийнх нь өсөлтөнд, өөрийнх нь эзэрхэх хүсэл зоригт тустай зүйлийг сайнаар үнэлдэг бөгөөд сул дорой байдлаа давж байдаг бол буурч буй амьдрал амар амгаланг эрэлхийлж, бусдын үнэлгээнд захирагдах ажээ.

Ийнхүү өөрийгөө хэрэгжүүлэх явдлыг амьдралын ноёлогч шинж хэмээн үзсэн тэрээр үнэт зүйлс, сайн, муугийн тулгуур баримжааг илэрхийлдэг ёс суртахуун тухайн амьдралын онцлогоос урган гарч өөр өөр байдаг хэмээн үзэж эзэн, хараатын хоёр ёс суртахуун байдаг гэж үзсэн байна.

Энэ хоёр ёс суртахууныг Ф.Ницше "ноёдын ёс суртахуун" хийгээд "боолчуудын ёс суртахуун" хэмээн нэрлэсэн (4). Ёс суртахууны талаархи түүний энэхүү үзэл санаа К.Марксын философитой огтолцох талтай.

Гэвч "боол" гэдгийг боол эзэмшлийн сонгодог харилцааны утгаар ойлгох нь хэт явцууруулсан хэрэг болно. Монгол хэлний "боол" гэдэг үг нь "боох" гэдэг үгнээс гаралтай мэт бөгөөд Ницшегийн философийн хүрээнд хүсэл зоригоо "боож" ямар нэг өөр давамгайлсан хүсэл зоригт өөрийгөө зориулах утгаар ойлгож болох юм.

Өөрийгөө хэрэгжүүлэх, биеэ хадгалан хамгаалж, амар амгаланг эрэлхийлэх амьдралын үндсэн хоёр талын аль давамгайлсан нь ноёлогч үнэт зүйлс, зам мөр, ёс суртахууныг тодорхойлох бөгөөд доройтон буй амьдрал үнэлж байна уу, өөдөлж буй амьдрал үнэлж байна уу гэсэн үүднээс үнэ цэнийг нь үнэлэх явдал түүний философийн гол зорилт болжээ.

Амьдралын ноёлогч шинж болсон эзэрхэх хүсэл зоригийн үүднээс хүсэл тэмүүллээ дагах, өөрийгөө нээлттэй, сайн дурын, Би гэсэн ёс суртахууныг тэрээр өсч буй амьдралын шинж гэж үзсэн бол амар амгаланг бодсон, хувиа үл хичээх, захирагдах, орчноос хараат, бусдыг гэсэн ёс суртахууныг ачаа дарамтны шинжтэй албадлагын ёс суртахуун гэж үзсэн.

Түүний энэхүү үзэл санааг нийгмийн амьд организмын нь хувьд өсөлт, бууралтын ээлж дараанд авч үзсэн онолуудын нэг эх сурвалж гэж үзэж болох юм. Хүчтэй зөн совиндоо хөтлөгсдөн тэрхүү организм зорилгодоо хүрч, бэлэн зэлэн байдалд орсон цагт хүсэл зориг нь суларч амар амгаланг эрэлхийлэх явдал давамгайлах болдог.

Өсөлтийн үедээ яваа нийгэм гадагш тэмүүлсэн "нээлттэй" шинж чанарыг агуулдаг бол буурч буй нийгэм "хаагдаж" биеэ нөөх тал нь давамгайлж орчноосоо хараат болдог Биеэ нөөж мөхөж буй нийгмийн цаашдын хувь заяа түүний төрүүлсэн шинэ организмын амьдрах чадвараас шалтгаалах ажээ.

Ийнхүү Ницше амьдралыг бүхэлд нь төдийгүй амьд бүхнийг, үүний дотор хувь хүн, нийгмийг ч өсөлт, хөгжилт, уналт, үхлийн дараалалд байдаг бөгөөд дотроосоо шинэ организм төрүүлж мөнх шинэчлэгдэж байдаг амьд организмын хувьд авч үзсэн гэж хэлж болно.

Харин амьдрал хөгжлийнхөө ямар үе шатанд байгааг ноёрхогч үнэт зүйлс, ёс суртахууны үзэл ойлголтоор нь тодорхойлж болно гэж тэрээр үзэж байв. Өөрийнхөө үеийн ноёлогч үнэлгээ гэж үзсэн амар амгаланг эрэлхийлсэн "энэрэнгүй", "бусдын төлөө" гэгдэх ёс суртахууныг тэрээр хийсвэр шинжтэй хэмээн үзэж өөрийн хүсэл зориггүй болгох мөхөлийн зам хэмээн үзэж, "мөнхийн" эдгээр үнэт зүйлсийг эргэн харахыг зорьжээ. (5)

Эдгээр үнэт зүйлсийг Ф.Ницше "Ёс суртахууны уг гарал" зохиолдоо "юу ч бус"-д тэмүүлсэн хүсэл зориг хэмээн нэрлэжээ. Гэвч энэхүү хүсэл зоригийн

ачаар хүсэл зориг нөөцлөгдсөн гэж үзэж (4,524) байсан тэрээр шинэ хүсэл зориг төрөх тухай, ирэх зуунуудад болох нийгмийн донсолгоон, үзэл суртлын дайнүүдын тухай зөгнөн бичиж, мөнх эргэлт, үлэмж хүний (8) тухай үзэл санаагаа дэвшүүлжээ. Энэ үзэл санаагий нь хувиа хичээх үзэл, өөрийн хүсэл зориг, өөрийн үнэт зүйлсийг номлосон сургаал гэж товчид нь тодорхойлж болох юм.

### Ном зохиол

- 1.Ф.Ницше. Рождение трагедии, или эллинство и пессимизм. – Ф.Ницше. Соч. в 2-х т.Т.1. М., 1990
- 2.Ф.Ницше. Так говорил Заратустра. Книга для всех и ни для кого. – Ф.Ницше. Соч. в 2-х т. Т.2.М., 1990
- 3.Ф.Ницше. По ту сторону добра и зла. Прелюдия к философии будущего – Мөн тэнд
- 4.Ф.Ницше. К. Генеалогии морали. Поломическая сочинение – Мөн тэнд
- 5.Ф.Ницше. Антихрист. Проклятие христианству-Мөн тэнд
- 6.М.Хайдеггер. Европейский нигилизм. – Проблема человека в западной философии М., 1988, 312 дахь тал
- 7.А.Шопенгауэр. Понятие воели – Артур Шопенгауэр. Избранные произведения. Ростов-на-Дону, 1997
- 8.С.Анудар. “Заратустра ингэж хэлж байв” зохиол дахь үлэмж хүний сургаал. Дипломын ажил, МУИС, 1994
- 9.Даниэль Галеви. Жизнь Фридриха Ницше. Рига, 1991.
- 10.Краткий очерк. истории философи М., 1967.
- 11.К.А.Свасьян Фридрих Ницше Мученик познания-Ф.Ницше. Соч.в 2-х т Т.1, М., 1990
- 12.Современная буржуазная философия. М., 1978, 292 дахь тал
- 13.Философский энциклопедический словарь. М., 1983.
- 14.О.Чимэг. Ницшегийн амьдралын философи – Ф.Ницшегийн “Эмгэнэлт жүжгийн үүсэл буюу эллин ёс ба гутрангуй үзэл”, “Христэд тэрслэгч” зохиолуудын монгол орчуулга дахь оршил өгүүлэл (хэвлүүлээгүй байгаа).УБ., 1993-1998 он
- 15.О.Чимэг Хайдеггерын философи дахь ахуйн үнэн ба”ахуйн орон гэр болох” хэлний тухай үзэл санааны эх сурвалж – “Эрх чөлөө ба философи” Дугаар 6. УБ., 2000.